



УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ТӨЛӨВШИЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч: МОНГОЛЫН ДИПЛОМАТЫН АКАДЕМИ
гүйцэтгэгч: МИРИМ КОНСАЛТАНТ ХХК

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ	5
НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ	6
1.1. Судалгааны зорилго, зорилтууд	6
1.2. Судалгааны хамрах хүрээ, түүвэр	6
1.3. Судалгааны чанарын хяналт	7
1.4. Судалгаанд оролцогчдын мэдээлэл	7
ХОЁР. ИРГЭДИЙН СОНГОЛТОД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС	9
ГУРАВ. НАМУУДЫН РЕЙТИНГ БОЛОН ЛИДЕРҮҮДИЙН РЕЙТИНГ	15
3.1. Улс төрийн намуудын рейтинг	15
3.2. Намуудын лидерүүдийн рейтинг	16
ДӨРӨВ. НАМУУДААС ХҮЛЭЭХ ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТ БОЛОН НАМЫН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА	20
4.1. Намуудаас хүлээх иргэдийн хүлээлт	20
4.2. Намуудын бодлого, үйл ажиллагаа	22
ТАВ. ДҮГНЭЛТ	24
ЗУРГАА. ХАВСРАЛТ	26

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Судалгааны түүвэр	5
Хүснэгт 10.	Таны санал өгөх шийдвэрт хэн эсвэл юу хамгийн ихээр нөлөөлсөн бэ? Орлогоор харьцуулсан (хамгийн их нөлөөлсөн 4 үзүүлэлт)	12

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Судалгаанд хамрагдагчдын нас, хүйсийн бүтэц	6
Зураг 2.	2016 оны сонгуульд санал өгсөн байдал	8
Зураг 3.	2016 оны сонгуулийн үр дүнд бий болсон нам, эвслүүдийн УИХ дахь суудлын тоо нь манай улсын өнөөгийн улс төрийн үзэл бодлыг бүрэн төлөөлж чадах эсэх (Хувиар)	8
Зураг 4.	2016 оны сонгуульд аль намын төлөөлөлд саналаа өгөхөө хэзээ шийдсэн бэ?	9
Зураг 5.	2016 оны УИХ-д дээрх намыг сонгохдоо ямар хүчин зүйлийг харгалзан сонголтоо хийсэн бэ?	10
Зураг 6.	2016 оны УИХ-д дээрх намыг сонгохдоо ямар хүчин зүйлийг харгалзан сонголтоо хийсэн бэ? Насаар харьцуулсан	11
Зураг 7.	Таны санал өгөх шийдвэрт хэн эсвэл юу хамгийн ихээр нөлөөлсөн бэ?	11
Зураг 8.	Та 2020 оны сонгуульд дараах намуудаас Аль намыг дэмжих оролцох вэ?	13
Зураг 9.	Та 2020 оны сонгуульд дараах намуудаас Аль намыг дэмжихгүй вэ?	13
Зураг 16.	Намуудын талаар Та ямар бодолтой байна вэ?	14
Зураг 17.	Таны хамгийн их дэмждэг улс орныг удирдаж чадах улс төрч	15
Зураг 18.	Таны бодлоор улс орныг удирдаж чадах хүн ямар байх ёстой вэ?	16
Зураг 10.	Сонгуулийн сурталчилгааны үеэр намууд, нэр дэвшигчдийн амласан амлалтууд биелэгдэх эсэхэд та хэр итгэлтэй байна вэ?	17
Зураг 11.	Монголын нийгмийн тулгамдсан асуудлууд болох ажилгүйдэл, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, авилга гэх мэт асуудлыг аль нам хамгийн сайн шидэж чадах вэ? (Сант Марал Сангийн судалгааны үр дүнтэй харьцуулсан байдал)	18
Зураг 12.	Монголын нийгмийн тулгамдсан асуудлууд болох ажилгүйдэл, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, авилга гэх мэт асуудлыг аль нам хамгийн сайн шидэж чадах вэ?	18
Зураг 13.	Таны бодлоор улс төрийн намуудаас аль нам хөгжлийн хувьд зөв чиглэлрүү явж байна вэ?	19
Зураг 14.	Таны бодлоор улс төрийн намуудаас аль нам хөгжлийн буруу чиглэл рүү явж байна вэ?	19
Зураг 15.	Таны бодлоор дараах бодлогуудыг аль нам хамгийн сайн хэрэгжүүлж чадах вэ?	17

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АН	Ардчилсан Нам
АТН	Ард Түмний Нам
АТХН	Ард түмнээ хайрлая нам
АТОЗН	Ард түмний олонхийн засаглал нам
БНН	Бүгд найрамдах нам
БЗД	Баянзүрх дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
ДМН	Дэлхийн монголчууд нам
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МҮАН	Монголын Үндэсний Ардчилсан Нам
МЭҮН	Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нам
МЛН	Монголын Либерал нам
МНН	Монголын Ногоон нам
МУНН	Монголын Уламжлалын Нэгдсэн нам
МЛАН	Монгол Либерал Ардчилсан нам
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
УИХ	Улсын Их Хурал
УБ	Улаанбаатар
ХҮН	Хөдөлмөрийн Үндэсний Нам
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны зорилго нь намуудын рейтинг, танигдсан байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс болон намуудын бодлого, үзэл баримтлалын талаарх иргэдийн хандлага, мэдлэгийг тодруулахад чиглэсэн. Судалгааг Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт зохион байгуулсан ба нийт 380 иргэнийг ажил эрхлэлтийн байдал, орлогын түвшин, 2016 онд аль нам хүчний төлөө саналаа өгсөн зэргийг харгалзан судалгаанд түүвэрлэн хамруулсан

Судалгааны зарим үр дүнгээс энэ хэсэгт хураангуйлан дурдвал иргэдийн хувьд төрийн эрх барьж байгаа МАН, АН, МАХН-ын талаар мэдээлэл сайтай боловч бусад улс төрийн хүчин, нам эвслүүдийн талаар мэдээлэл хангалтгүй байна. Иргэд сонгуулиар дамжуулан сонгож баталгаажуулсан улс төрийн үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид болох УИХ дэх намын төлөөллийг иргэдийн улс төрийн үзэл баримтлал, үнэт зүйлсийг төлөөлж чадахгүй хэмээн судалгаанд оролцогчдын 60 хувь үзэж байна. Мөн иргэд улс төрийн сонголт хийхдээ урт хугацааны хүчин зүйлс бус тухайн цаг үеийн нөхцөл байдал, үйл хөдлөлд хөтлөгдсөн буюу сонгуулийн нөхцөл байдал, уур амьсгал зэрэгт үндэслэн сонгуулийн өдөр болон сонгуулийн сурталчилгааны өдрүүдэд судалгаанд оролцогчдын 62 хувь шийдвэрээ гаргаж сонголт хийж байна.

Иргэд тал буюу 41.6 хувь улс төрийн шийдвэр гаргахдаа намуудын бодлого, мөрийн хөтөлбөрт суурилсан үндэслэл бүхий оновчтой шийдвэр гаргаж чадахгүй байна. Мөн иргэдийн 59 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад субъектийн нөлөөлөлд автан сонголт хийж байгаа нь улс төрийн хүлээн зөвшөөрөгдөхүйц бие даасан шийдвэр болж чадахгүй байна.

Иргэдийн намуудад итгэх итгэл маш сул буюу намуудын сөрөг дэмжлэг өндөр, эерэг дэмжлэг маш бага байна. Олон ургальч үзэл бодлыг илэрхийлсэн олон намын тогтолцоонд иргэдийн итгэх итгэл суларсан байна. Харин намын хэрэг байхгүй хүчтэй ерөнхийлөгчийн засаглал байх шаардлагатай гэсэн иргэдийн хандлага нэмэгдсэн байна.

Иргэдийн намуудаас хүлээх хүлээлт маш бага буюу иргэдийн 82 хувь намуудын өгсөн сонгуулийн амлалт, мөрийн хөтөлбөр биелэхгүй гэсэн хүлээлттэй байна. Иргэдийн дийлэнх нь намуудыг бодлого хөтөлбөр, үзэл баримтлалын хувьд буруу чиглэлд хөгжиж байна хэмээн тодорхойлж байна. Мөн иргэдийн хувьд улс төрийн нам, эвслүүдийн бодлого, үзэл баримтлал, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн талаарх мэдлэг, ойлголт маш сул байна.



СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Энэхүү тандалт судалгааны ажлыг Монголын дипломатын академи болон Монгол дэх Конрад-Аденауэр сангийн удирдлага дор МИРИМ Консалтант ХХК нь 2019 оны 09 сарын 06-наас 15-ны өдрүүдэд гүйцэтгэсэн. Мөн МИРИМ Консалтант ХХК-ийн өмнө гүйцэтгэж байсан ижил төстэй ажлуудын үр дүнг харьцуулан ашигласан болно.

1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэхүү судалгааны зорилго нь намуудын рейтинг, танигдсан байдал, түүнд иргэдийн сонголтод нөлөөлөгч хүчин зүйлс болон намуудын бодлого, үзэл баримтлалын талаарх иргэдийн хандлага, мэдлэгийг тодруулахад чиглэнэ. Судалгаа нь дараах асуудлуудыг гүнзгийрүүлэн судална. Үүнд:

1. *Улс төрийн намуудын рейтинг болон танигдсан байдлын үнэлгээ:* Намуудын рейтингийг тодорхойлж, рейтингийг өсгөж бууруулж байгаа гол хүчин зүйлсийг тодорхойлох. Мөн улс төрийн эрх баригч намууд болох МАН, АН, МАХН-аас бусад бусад намуудын талаарх иргэдийн ойлголтыг судалж тодорхойлно.
2. *Улс төрийн намуудын бодлого, үзэл баримтлалын талаарх иргэдийн ойлголт хандлагыг тодорхойлох:* Иргэдийн сонголтод улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөр хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход чиглэнэ.

1.2. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭР

Судалгаанд хамрагдсан иргэдийн гэрээр зочилж ганцаарчилсан ярилцлага судалгааны аргаар мэдээлэл цуглуулсан. Энэ удаагийн судалгааг Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг болох Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн сонгуулийн насны **380** иргэнээс асуулга судалгааны аргаар мэдээлэл цуглуулав. Ингэхдээ стандартчилсан асуумжын аргыг ашиглан зорилтот бүлгээс мэдээлэл цуглуулсан. Судалгааны мэдээллийг 2016 оны сонгуульд санал өгч оролцсон одоогийн байдлаар 21-ээс дээш насны иргэдийг судалгаанд хамрууллаа. Судалгаанд өрхөөс сонгуулийн насны нэг оролцогчийг сонгож судалгаанд хамруулав.

Хүснэгт 1. Судалгааны түүвэр

№	Хороо	Асуулга судалгаа
1	Хотын захын гэр хорооллын орлого багатай өрх	180
2	Хотын төвийн орон сууцны дундаж орлоготой өрх	200
Нийт		380

Улаанбаатар хотын захын гэр хорооллын орлого багатай 180 иргэн, хотын төвийн орон сууцанд амьдардаг дундаж орлоготой 200 иргэнийг судалгаанд хамруулсан. Түүврийн аргачлал нь олон шаталт, магадлалт түүврийн аргыг ашигласан.

Судалгааны мэдээллийг Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн 21-ээс дээш насны 861,288 иргэнээс ± 5 хувийн алдааны хязгаар дотор 95 хувийн итгэлтэйгээр төлөөлөх чадвар бүхий 380 иргэнийг асуулга судалгаанд хамрууллаа. Түүврийн аргачлал нь олон шатлалт, магадлалт түүврийн арга бөгөөд тооцоололд дээрх томъёог хэрэглэв.

$$n = \frac{t^2 \cdot w \cdot (1-w) \cdot N}{N \cdot \Delta_p^2 + t^2 \cdot w \cdot (1-w)}$$

Судалгаа авах байршлын төв хэсэгт очиж эхлэлийн цэгийг тодорхойлсны дараа тогтоосон интервалын дагуу судалгаанд хамрагдах өрхийг сонгосон.

1.3. СУДАЛГААНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ

Судалгааны явцад дараах хяналтуудыг хийсэн.

- Талбарын хяналт.** Талбарын мэдээлэл цуглуулах явцад ахлах судлаач талбарын судлаачдын үйл ажиллагааг хөндлөнгөөс 80 хувьд нь хяналт тавьж ажилласан.
- Утсан хяналт.** Оролцогчдоос утасны дугаарыг нь авсан бөгөөд талбараас ирсэн мэдээллийг давхар хянаж, нийт судалгаанд оролцогчдын 10 хувьд нь утсаар холбогдож мэдээллийг хянасан.
- Бичлэгтэй тулгах хяналт.** Судалгааг авахдаа нийт анкетын 95 орчим хувьд нь бичлэг хийж баримтжуулсан. Авсан анкетын 20 хувийг бичлэгтэй тулгаж агуулгыг шалгасан.

1.4. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Судалгааны анхдагч мэдээлэл цуглуулах явцад судалгаанд оролцогчдын нас, хүйс болон боловсролын хувьд олон ялгаатай бүлгийг төлөөлж чадахуйц байлгахаар төлөвлөж ажилласан. Судалгаанд оролцогчдын 42,9 хувь нь эрэгтэй, 57.1 хувь нь эмэгтэй байна.

Нийт судалгаанд оролцогчдын 17,1 хувь нь 24 хүртэлх насныхан, 31,3 хувь нь 25-34 насныхан, 17,1 хувь нь 35-44 насныхан, 16,8 хувь нь 45-54 насныхан, 17,6 хувь нь 55-аас дээш насныхан хамрагдсан байна.

Зураг 1. Судалгаанд хамрагдагчдын нас, хүйсийн бүтэц

№	Асуулт	Хариулт	Тоо	Хувь %
1	Хүйс	Эрэгтэй	163	42,9
		Эмэгтэй	217	57,1
2	Нас	24 хүртэл	65	17,1
		25-34	119	31,3
		34-44	65	17,1
		45-54	64	16,8
		55-аас дээш	67	17,6
3	Боловсрол	Дээд	191	50,3
		Бүрэн дунд	160	42,1
		Бүрэн бус дунд	25	6,6
		Бага	4	1,1
4	Ажил эрхлэлт	Төрийн байгууллага	57	15
		Хувийн байгууллага	133	35
		Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	87	22,9
		Суралцдаг (оюутан, сурагч)	29	7,6
		Тэтгэвэрт, ХБИиргэн	56	14,7
		Эрхэлсэн ажилгүй	17	4,5
5	Орлого	ОУ-ын байгууллага	1	0,3
		300,000 хүртэл	47	12,4
		300,001-700,000	119	31,3
		700,001-1,100,000	107	28,1
		1,100,001-1,600,000	68	18,1
6	Улс төрийн намын гишүүн үү	1,600,001-аас дээш	39	10,1
		Тийм	48	12,6
		Үгүй	332	87,4

Боловсролын түвшингийн хувьд дээд боловсролтой оролцогчид 50.3 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчид 42.1 хувь, бүрэн бус дунд боловсролтой оролцогчид 6.6 хувь, бага боловсролтой иргэд 1.1 хувийг эзэлсэн байна.

Ажил эрхлэлтийн хувьд төрийн байгууллагад ажиллагчид 15 хувь, хувийн байгууллагад 35 хувь, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 22.9 хувь, суралцдаг 7.6 хувь, тэтгэврийн иргэд 14.7 хувь, эрхэлсэн ажилгүй 4.5 хувь, Олон улсын байгууллагад ажилладаг 0.3 хувийн төлөөлөлтэй хамрагдсан нь нийт хүн амын ажил эрхлэлтийн бүтцийг төлөөлсөн байна.

Судалгаанд хамрагдсан оролцогчдын хувьд 300000 хүртэл төгрөгийн орлоготой 12,4 хувь, 300,001-700,000 орлоготой оролцогчид 31,3 хувь, 700,001-1,100,000 орлоготой оролцогчид 28,1 хувь, 1,100,001-1,600,000 орлоготой оролцогчид 18 хувь, 1,600,001-аас дээш төгрөгийн орлоготой оролцогчид 10,1 хувь хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдын өрхийн орлогын дундаж түвшин 944,842 төгрөг байна. Үүнээс үзвэл судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлого нь статистикийн ерөнхий хорооноос гаргасан Монгол улсын өрхийн сарын дундаж орлого болох 1,100,000 төгрөгтэй ойролцоо байна.


Судалгаанд оролцогчдын 12,6% намын гишүүнчлэлтэй бол 87,4% намын гишүүнчлэл байхгүй байна.



ИРГЭДИЙН СОНГОЛТОД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгаанд хамрагдсан оролцогчдын 34.2 хувь нь Ардчилсан намын төлөө, 33.2 хувь нь Монгол Ардын Намын төлөө, 12.6 хувь нь Монгол Ардын Хувьсгалт Намын төлөө, 20 хувь нь Бие даан нэр дэвшигчийн төлөө 2016 онд саналаа өгсөн сонгогчид хамрагдсан. Бид судалгаанд оролцох оролцогчдыг сонгохдоо 2016 оны УИХ-н сонгуульд аль нам, хүчний төлөө саналаа өгсөн байдлыг чухалчлан үзэж судалгаанд тэнцүү хамруулсан. Ингэснээр сонгогчдын сонголтод ямар хүчин зүйлс түлхүү нөлөөлж тэнцвэртэй тодорхойлох боломж бүрдэнэ.


Зураг 2. 2016 оны сонгуульд санал өгсөн байдал



Хүчин зүйл 1:

Судалгаанд оролцогчдын 60% нь 2016 оны сонгуулийн үр дүнд бий болсон нам, эвслүүдийн УИХ дахь суудлын тоо нь **өнөөгийн нам, улсын төрийн үзэл баримтлалыг төлөөлж чадахгүй хэмээн үзсэн байна**. Мөн судалгаанд оролцогчдын 19% нь санал нийлж байна гэсэн хариултыг өгсөн бол 21% нь мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн. Өөрөөр хэлбэл ард түмний төлөөлөл болж сонгуулиар сонгогдсон УИХ-ийн гишүүд тэр дундаа төрийн эрхийг барьж буй одоогийн эрх барьж буй намын үзэл баримтлал нь нийт иргэдийн улс төрийн үзэл бодлыг төлөөлж чадахгүй хэмээн үзэж байна.

Зураг 3. 2016 оны сонгуулийн үр дүнд бий болсон нам, эвслүүдийн УИХ дахь суудлын тоо нь манай улсын өнөөгийн улс төрийн үзэл бодлыг бүрэн төлөөлж чадах эсэх (Хувиар)



2016 оны сонгуулийн үр дүнд бий болсон **УИХ дахь суудлын тооны давамгайл байдал нь иргэдийн өнөөгийн улс төрийн үзэл бодлыг бүрэн төлөөлж чадах эсэх нь 2016 онд аль нам, хүчний төлөө санал өгсөнтэй хамааралгүй байна.** Тухайлбал 2016 онд МАН-д саналаа өгсөн сонгогчийн хувьд ч одоогийн бий болсон үзэл баримтлал нь иргэдийн өнөөгийн улс төрийн үзэл бодлыг бүрэн төлөөлж чадахгүй гэж үзсэн байна. Энэ нь дараах шалтгаантай байж болохоор байна. Үүнд:

- Тухайн намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэдийн итгэх итгэл сул
- Тухайн намын үзэл баримтлал, бодлого хөтөлбөрийн талаарх иргэдийн ойлголт мэдлэг муу
- Нэг намын үзэл баримтлал, нөгөө намын үзэл баримтлалаас ялгарах ялгарал багатай холбоотой байж болно.

Судалгаанд оролцогчдын насаар харьцуулж үзвэл сонгогчдын нас залуужих тусам 2016 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ дэх намын суудлын давамгайл байдал нь иргэдийн улс төрийн үзэл бодлыг тодорхойлж бүрэн чадахгүй гэж үзэх хандлага илүү давамгайлж байгаа бол нас ахих тусам хүлээн зөвшөөрөх хандлага бага зэрэг ажиглагдаж байсан.


Боловсролын түвшингээр харьцуулж харахад бага боловсролтой иргэдийн 75% улс төрийн үзэл бодлыг төлөөлж чадахгүй байна гэж хариулжээ. Харин дээд боловсролтой иргэдийн хувьд мөн л 57.1% төлөөлж чадахгүй байна гэж үзсэн байна. Боловсролын байдлаас харахад томоохон ялгаа харагдахгүй байна. Өөрөөр хэлбэл улс төрийн үзэл бодлыг төлөөлөх түүний төлөөлж ажиллаж чадахгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Хүчин зүйл 2:

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 26.3 хувь нь сонгуулийн өдөр, 35.8 хувь нь сонгуулийн сурталчилгааны өдрүүдэд, 21.6 хувь нь тухайн намын бодлого чиглэлийг дэмжиж, 5.3 хувь нь намын гишүүн учраас сонголтоо хийсэн байна. Үүнээс үзвэл намын бодлого, үйл ажиллагааг дэмжиж саналаа өгч байгаа иргэд 26.9 хувь байгаа бол сонгуулийн нөхцөл байдал, уур амьсгал зэрэгт үндэслэн сонгуулийн өдөр болон сонгуулийн сурталчилгааны өдрүүдэд шийдвэр гаргаж байгаа иргэд 62.1 хувь байна. **Үүнээс дүгнэж үзвэл иргэд намын үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрт үндэслэн сонголт хийхээс илүүтэй тухайн сонгуулийн үеийн нөхцөл байдал, уур амьсгалд үндэслэж шийдвэр гаргах хандлага давамгайлж байна.**

Энэ нь улс төрийн намуудын төлөвшил хангалтгүй байгаатай холбоотой байж болно. Ардчилсан сонгууль явагдаж эхэлснээс хойших 30 орчим жилийн хугацаанд хий хоосон амлалт бус ажил хэрэгч байдлаар мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн бодит төсөөлөлтэй, сонгуулийн мөрийн хөтөлбөр, бодлогоо бодитой хэрэгжүүлж ирсэн нам одоог хүртэл байгаагүйтэй холбоотой юм. Энэ нь улс төрийн намын зохион байгуулалтаар дамжуулан төрийн эрх мэдлийг удирдан явуулах тогтолцоонд итгэх сонгогчидийн итгэлийг бууруулж буй юм.

Зураг 4. 2016 оны сонгуульд аль намын төлөөлөлд саналаа өгөхөө хэзээ шийдсэн бэ?



Энэхүү үзүүлэлтийг нас, хүйс, боловсролын түвшингээр харьцуулан үзэхэд төдийлөн ялгаатай байдал ажиглагдахгүй байна.


Хүчин зүйл 3:

Тухайн нам улс төрийн хүчний төлөө санал өгөхөд юуг харгалзан үзсэнийг тодруулахад 31.7 хувь нь намын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, 26.7 хувь намын баримталдаг бодлого хөтөлбөр, 24.8 хувь тухайн намаас нэр дэвшигчийн хувь хүний шинж чанарыг харгалзан сонголтоо хийсэн байна. Эндээс намын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, намын баримталдаг бодлого хөтөлбөрийг харгалзан үзэж санал өгсөн байдал 58.4 хувь буюу судалгаанд оролцогсдын 60 орчим хувийг эзэлж буй нь сайшаалтай үзүүлэлт байна.

24.8 хувь тухайн намаас нэр дэвшигчийн хувь хүний шинж чанарыг харгалзан үзэж буй байдал, 15.6 хувь нь өөр сайн нэр дэвшигч байгаагүй гэдэг нь анхаарал хандуулах ёстой асуудал болно. Үүний үр дүнд нь хуулиар бий болгосон төрийн байгуулалт, тогтолцоонд итгэхээ байж, харин тохиолдлын шинжтэй хий хоосон найдвар дээр түшиглэж сонголт хийдэг сонгогчидтой болсныг илтгэнэ. Энэ нь манай улсын сонгогчдын боловсрол муу байгаагаас хамаараад сонгогчид бидний байгуулахыг зорьж буй Үндсэн хуульт төрийн байгууллын суурь зарчмуудыг ухамсарлаж ойлгож, түүнд итгэж үнэмших байдал сул байгаатай холбоотой юм.


Тодорхой нэг хувь хүн гэхээсээ нэгдмэл үзэл санаа, зарчмын доор олон тооны этгээд оролцон бүтэцлэгдсэн тогтолцоогоор улс орныг удирдан явуулах, төрийн хэргийг хэрэгжүүлэх ёстойг төдийлөн нийтлэг олонхи нь ухамсарлаагүй байгаатай холбоотой.

Зураг 5. 2016 оны УИХ-д дээрх намыг сонгохдоо ямар хүчин зүйлийг харгалзан сонголтоо хийсэн бэ?



Иргэдийн хувьд нас ахих тусам намын мөрийн хөтөлбөр, бодлого үзэл баримтлалыг харж сонголтоо хийх хандлага давамгайлж байгаа бол харин 25-44 нас буюу иргэдийн нас залуужих тусам намаас нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг харж сонголтоо хийх байдал өссөн байна.

Зураг 6. 2016 оны УИХ-д дээрх намыг сонгохдоо ямар хүчин зүйлийг харгалзан сонголтоо хийсэн бэ? Насаар харьцуулсан




Ажил эрхлэлтийн хувьд аваад үзвэл төрийн байгууллага ажилладаг иргэдийн хувьд тухайн намыг сонгохдоо намаас нэр дэвшигчийн хардаг бол хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуус сонголтоо хийхдээ тухайн намын мөрийн хөтөлбөр, намын үзэл баримтлал, бодлого үйл ажиллагааны чиглэлийг илүү харж саналаа өгсөн байна.

Хүчин зүйл 4:

УИХ-ын сонгуульд санал өгөхөд 33 хувь нь тухайн намын бодлого, мөрийн хөтөлбөр, 20 хувь нь хэвлэл мэдээлэл, 12 гэр бүлийн гишүүд, найз нөхөд хамгийн ихээр нөлөөлсөн гэсэн байна. Харин сонголтоо зөвхөн өөрийнхөө бодлоор хийсэн гэж 8% хариулсан байна.

Зураг 7. Таны санал өгөх шийдвэрт хэн эсвэл юу хамгийн ихээр нөлөөлсөн бэ?



Тухайлбал иргэд улс төрийн сонголт хийхдээ намын бодлого, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон өөрийн үзэл бодолд тулгуурлан сонголт хийсэн байдал 41 хувь байгаа бол, 59 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад субъектийн нөлөөлөлд автагдаж сонголт хийж байна. **Үүнээс үзвэл Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намуудад итгэлтэй, үнэнч дэмжигч сонгогч байхгүй байгааг харуулж байна.**

Судалгаанд оролцогчдын орлогын зөрүүтэй байдал хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад субъектийг нөлөөлөлд автагдаж санал өгч буй байдалтай нь хамааралтай байна. Тухайлбал иргэдийн орлого багасах хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад субъектийн нөлөөлөлд автах байдал нэмэгдэж байгаа бол, орлого ихсэх тусам нөлөөнд автах байдал багассан байдал харагдаж байна.

Хүснэгт 2. Таны санал өгөх шийдвэрт хэн эсвэл юу хамгийн ихээр нөлөөлсөн бэ? Орлогоор харьцуулсан (хамгийн их нөлөөлсөн 4 үзүүлэлт)

	Намын бодлого эсвэл нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр	Хэвлэл мэдээлэл	Гэр бүлийн гишүүд/ хамаатан садан/найз нөхөд	Өөрийнхөө бодлоор
300,000 хүртэл	36%	24%	27%	18%
300,001-700,000	45%	29%	15%	6%
700,001-1,100,000	43%	19%	14%	8%
1,100,001-1,600,000	42%	25%	12%	14%
1,600,000-аас дээш	43%	30%	13%	13%

Харин судалгаанд оролцогчдыг насаар харьцуулж үзэхэд оролцогчдын нас залуужих тусам хэвлэл мэдээлэл, гэр бүл, интернет, сошиал медиа хамгийн ихээр нөлөөлсөн байдал давамгайлж байгаа бол харин оролцогчдын нас ахих тусам тухайн намын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг харж сонголтоо хийсэн байна.



НАМ БОЛОН ЛИДЕРҮҮДИЙН РЕЙТИНГ


3.1. УЛС ТӨРИЙН НАМЫН РЕЙТИНГ

2020 оны сонгуульд одоогийн нам хүчнийг дэмжиж саналаа өгөх иргэдийн саналын хувийг авч үзвэл 19.2 хувь нь МАН, 18.4 хувь нь АН, 10 хувь нь МАХН, 11.7 хувь нь бусад нам төлөө саналаа өгнө гэсэн бол **45,9 хувь** аль намд саналаа өгөхөө мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн. Харин 2020 оны сонгуульд нам хүчнийг дэмжихгүй вэ гэдгийг тодруулахад **48 хувь нь АН, 44 хувь нь МАН**, 4.5 хувь нь МАХН, 15.8 хувь бусад нам хүчний төлөө саналаа өгөхгүй гэсэн бол 9,5 хувь нь ямар нэг шийдвэр гаргаагүй буюу мэдэхгүй байна.


Тухайн намуудыг дэмжихгүй гэдэг хариултын хувь дэмжинэ гэж хариулсан хувиасаа 20-оос 25 пунктээр их байна. Үүнээс үзвэл намуудын сөрөг дэмжлэг өндөр, эерэг дэмжлэг бага байна. Мөн намууд өөрсдийн дэмжигчдийг тасралтгүй алдаж байгааг харуулж байна.

Энэхүү асуултыг асуухдаа иргэдээс нээлттэй байдлаар асуусан ба тухайн иргэн өөрийн дэмжиж байгаа болон дэмжихгүй байгаа намынхаа нэрийг нээлттэй байдлаар хэлэх боломжоор хангасан. **Үүнээс үзвэл одоогийн эрх барьж байгаа намуудын бодлого, үйл ажиллагаа иргэдийн хүлээлтэд төдийлөн нийцэхгүй байгааг харж болно.**

Зураг 8. Та 2020 оны сонгуульд дараах намуудаас Аль намыг дэмжих оролцох вэ?




Зураг 9. Та 2020 оны сонгуульд дараах намуудаас Аль намыг дэмжихгүй вэ?



Олон ургальч үзэл бодлыг илэрхийлсэн олон намын тогтолцоонд иргэдийн итгэх итгэл суларсан байна. Тухайлбал судалгаанд оролцогчдын дийлэнх буюу **59,5 хувь** ер нь намын хэрэг байхгүй хүчтэй ерөнхийлөгчийн засаглал байх ёстой гэсэн үзэл давамгайлж байгаа бол үүний зэрэгцээ гурав дахь хүчин гэж хэрэггүй хоёр намтай байхад хангалттай гэсэн үзэл **13,9 хувийг** бүрдүүлж байгаа нь намд итгэх улам **сул** байгааг харуулж байна. Харин олон ургальч үзэл бодол бүхий олон намын тогтолцоотой байх ёстой гэж иргэдийн **14.7 хувь нь** үзэж байна

Зураг 10. Засаглалын хэлбэрийн асуултын үр дүн Сант Марал сангийн судалгааны үр дүнтэй харьцуулсан байдал



Энэхүү үр дүнг Сант Марал сангийн 2019 оны 04 сард гүйцэтгэсэн судалгаатай харьцуулж үзэхэд намуудын хэрэг байхгүй-хүчтэй ерөнхийлөгчтэй байх нь зөв өгсөн хариултын хувь 6-н пунктээр өссөн байна. Үүнээс үзвэл намуудын нэр хүнд тогтмол суларч байгааг харуулж байна.

3.2. НАМЫН ЛИДЕРҮҮДИЙН РЕЙТИНГ


Судалгаанд оролцогчдын нэрлэснээр хамгийн өндөр рейтингтэй улс төрчдийн жагсаалтын гаргахад 34.6 хувиар У. Хүрэлсүх (Ерөнхий сайд), 20.8 хувиар Х.Баттулга (Ерөнхийлөгч), 17.8 хувиар Л.Оюун-Эрдэнэ (ЗГХЭГ-ын дарга), 12.3 хувиар Н. Энхбаяр (МАХН-н дарга), 10.4 хувиар Ж.Батзандан (УИХ-ын гишүүн) нар тэргүүлж байна. Эдгээр улс төрчдийн рейтинг өндөр байхад намын суурь рейтинг эерэг нөлөө үзүүлж байна.

Зураг 11. Таны хамгийн их дэмждэг улс орныг удирдаж чадах улс төрч

У. Хүрэлсүх	34.6%	Д. Оюунхорол	1.1%
Х. Баттулга	20.8%	Д. Хаянхярваа	1.1%
Л. Оюун-Эрдэнэ	17.8%	З. Нарантуяа	.4%
Н. Энхбаяр	12.3%	Л. Гүндалай	.7%
Ж. Батзандан	10.4%	Ё. Баатарбилэг	.4%
Б. Жаргалсайхан	8.2%	С. Чинзориг	.7%
С. Жавхлан	7.1%	Ц. Мөнхоргил	.7%
Г. Занданшатар	7.1%	Б. Наранхүү	.4%
Ц. Нямдорж	5.6%	Д. Тэрбишдава	.7%
С.Ганбаатар	5.2%	Д. Эрдэнэбат	.7%
Л. Болд	3.3%	С.Баяр	.4%
Б. Бат-Эрдэнэ	2.2%	Ш. Раднаасэд	.4%
Т. Аюурсайхан	2.2%	Н. Алтанхуяг	.7%
Н. Учрал	1.9%	Д. Лүндээжанцан	.4%
С. Эрдэнэ	1.9%	М. Батчимэг	.4%
Р. Амаржаргал	1.9%	Э. Батүүл	.7%
Ц. Даваасүрэн	1.9%	Б. Дэлгэрсайхан	.4%
Х. Нямбаатар	1.5%	С. Оюунгэрэл	.4%
Н.Номтойбаяр	1.1%	Ч. Улаан	.4%
М. Энхболд	1.1%	М. Энхсайхан	.4%
Л. Энх-Амгалан	1.1%	Д. Сарангэрэл	.4%
Ч. Хүрэлбаатар	1.1%	О. Баасанхүү	.7%

МЭК судалгааны байгууллагаас 2019 оны 06 сарын рейтингтэй харьцуулахад 2019 оны 09 сарын байдлаар Ерөнхий сайд У. Хүрэлсүхийн рейтинг 10 пунктээр өсөж, бусад улс төрчдийн рейтинг 5-13 пунктээр буурсан байна.

Зураг 12. Жагсаалтыг тэргүүлж байгаа улс төрчдийн рейтингийг МЭК судалгааны байгууллагын 2019 оны 06 сарын судалгааны үр дүнтэй харьцуулсан байдал



У.Хүрэлсүх улс төрчийг дэмжигчдийн нийтлэг төрхийг тодорхойлбол: 35-54 насны, бүрэн дунд боловсролтой, хувийн байгууллагад ажилладаг, өрхийн орлогын хувьд бага/дунд орлоготой, 2016 оны сонгуулиар МАН төлөө саналаа өгсөн, 2020 оны сонгууль МАН-ыг дэмжиж оролцох хандлагатай, эрэгтэйчүүд давамгайлж байна.

Х.Баттулга улс төрчийг дэмжигчдийн нийтлэг төрхийг тодорхойлбол: 21-34 насны, бүрэн дунд боловсролтой, хувийн байгууллагад ажилладаг, өрхийн орлогын хувьд бага орлоготой, 2016 оны сонгуулиар АН төлөө саналаа өгсөн, 2020 оны сонгууль АН-ыг дэмжиж оролцох хандлагатай, эрэгтэйчүүд давамгайлж байна.

Л. Оюун-эрдэнэ улс төрчийг дэмжигчдийн нийтлэг төрхийг тодорхойлбол: 35-54 насны, дээд боловсролтой, хувийн байгууллагад ажилладаг, өрхийн орлогын хувьд бага орлоготой, 2016 оны сонгуулиар МАН төлөө саналаа өгсөн, 2020 оны сонгууль АН-ыг дэмжиж оролцох хандлагатай, эрэгтэйчүүд давамгайлж байна.

Иргэдийн хувьд сайн удирдагч нарт байх ёстой шинж чанар тодорхойлсон ба 52 хувь **ШУДАРГА**, 14.9 хувь **АРД ИРГЭДЭЭ СОНСДОГ, НЭЭЛТТЭЙ**, 13.1 хувь **УЛС ОРНЫХОО ТӨЛӨӨ СЭТГЭЛТЭЙ** байх гэсэн хариултыг дийлэнх оролцогчид сонгосон байна. Иргэд сайн улс төрчийг ШУДАРГА байх ёстой хэмээн үзэж байна.

Зураг 13. Таны бодлоор улс орныг удирдаж чадах хүн ямар байх ёстой вэ?

№	Сайн улс төрчийн шинж чанарууд				
1	Шударга	52.0%	14	Удирдах чадвартай	.6%
2	Ард иргэдээ сонсдог, нээлттэй	14.9%	15	Бусдын төлөө гэсэн сэтгэлтэй	.3%
3	Улс орныхоо төлөө сэтгэлтэй	13.1%	16	Ухамсартай	.3%
4	Мэдлэг боловсролтой	10.9%	17	Тууштай	.9%
5	Амласандаа хүрдэг	7.0%	18	Даруу төлөв	.6%
6	Өөрийн гэсэн үзэл бодолтой	3.3%	19	Зорилготой	.9%
7	Хариуцлагатай	3.3%	20	Ажил хэрэгч	.3%
8	Манлайлагч	3.0%	21	Хөдөлмөрч	.9%
9	Хүн чанартай	2.4%	22	Итгэл даасан	.6%
10	Үндэсний үзэлтэй	2.1%	23	Туршлагатай	.6%
11	Шуналгүй	1.8%	24	Асуудлыг шийдэж чаддаг	.3%
12	Зөв бодолтой	1.5%	25	Ёс суртахуунтай	.6%
13	Зарчимч	1.2%			

Сайн улс төрчийн шинж чанаруудыг иргэд өөрсдийн хүйсийн онцлогоос хамааран ялгаатай байдлаар тодорхойлж байна. Тухайлбал эрэгтэйчүүдийн хувьд ард иргэдээ сонсдог, мэдлэг боловсролтой, туршлагатай, хөдөлмөрч, Монгол улсаа гэсэн сэтгэлтэй гэсэн шинж чанарыг илүүтэй сонгосон бол эмэгтэйчүүдийн хувьд шударга, өөрийн гэсэн үзэл бодолтой гэсэн шинж чанаруудыг түлхүү сонгосон байна.

Рейтингийн хувьд тэргүүлж 5 улс төрчийн сайн удирдагчийн шинж чанаруудыг иргэд дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал жагсаалтын 1-рт бичигдэж байгаа ерөнхий сайд У. Хүрэлсүхийг иргэдийн 66.7 хувь нь зорилготой, 50 хувь манлайлагч, 50 хувь удирдах чадвартай, 45.5 хувь өөрийн гэсэн үзэл бодолтой, 29 хувь нь шударга хэмээн тодорхойлсон байна.

Хүснэгт 3. Жагсаалтыг тэргүүлж байгаа 5 лидер улс төрчийн давамгайлсан чанарууд

У. Хүрэлсүх	Х. Баттулга	Л. Оюун-эрдэнэ	Н. Энхбаяр	Ж. Батзандан
Зорилготой-66.7%	Хөдөлмөрч-66.7%	Тууштай-33.3%	Хариуцлагатай-27.3%	Даруу төлөв-50%
Манлайлагч-50%	Тууштай-66.7%	Хөдөлмөрч-33.3%	Мэдлэг боловсролтой-16.7%	Шуналгүй-33.3%
Удирдах чадвартай-50%	Даруу төлөв-50%	Үндэсний үзэлтэй-28.6%	Шуналгүй-16.7%	Үндэсний үзэлтэй-14.3%
Өөрийн гэсэн үзэл бодолтой-45.5%	Ёс суртахуунтай-50%	Өөрийн гэсэн үзэл бодолтой-27.3%	Ард иргэдээ сонсдог, нээлттэй-12.2%	Ард иргэдээ сонсдог, нээлттэй-10.2%
Шударга-29,2%	Хүн чанартай-50%	Зарчимч-25%		Мэдлэг боловсролтой-8.3%

У. Хүрэлсүх, Х.Баттулга нарыг “шударга” гэж үздэг иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна. Мөн Л. Оюун-эрдэнэ, У. Хүрэлсүх, Х.Баттулга нарыг “иргэдээ сонсдог, нээлттэй улс төрч” гэж үздэг иргэдийн дийлэнх эмэгтэйчүүд байна. Харин Х.Баттулга, У.Хүрэлсүх нарыг “Улс, орныхоо төлөө сэтгэлтэй” гэж үздэг иргэдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байна.




НАМУУДААС ХҮЛЭЭХ ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТ БОЛОН НАМЫН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. НАМУУДААС ХҮЛЭЭХ ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТ

Иргэдээс улс төрийн нам, эвслүүдийн сонгуулийн амлалт, тэдгээрт итгэх итгэлийг тодруулах зорилгоор сонгуулийн сурталчилгааны үеэр дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр биелэх эсэхэд та хэр итгэлтэй байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 40 хувь нь ерөнхийдөө итгэлгүй, 37.6 хувь огт итгэлгүй байгаа бол, 1.3 хувь нь бүрэн итгэлтэй, 16.6 хувь ерөнхийдөө итгэлтэй гэсэн хариултыг өгсөн байна. Судалгааны дүнгээс үзвэл иргэдийн 82,1 хувь улс төрийн намуудыг сонгуулийн амлалт, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж чадахгүй гэж дүгнэж байна. Үүнээс үзвэл улс төрийн намууд бодлогоо хэрэгжүүлэх чадавхад иргэд итгэл сул байгаа нь ажиглагдаж байна.

Зураг 14. Сонгуулийн сурталчилгааны үеэр намууд, нэр дэвшигчдийн амласан амлалтууд биелэгдэх эсэхэд та хэр итгэлтэй байна вэ?




Судалгаанд оролцогчдын хувьд намуудын сонгуулийн үеэр амласан амлалтууд биелэх эсэхэд итгэлтэй, итгэлгүй байх нь аль намын төлөө саналаа өгсөнтэй огт хамааралгүй байна.

Хүснэгт 4. Сонгуулийн сурталчилгааны үеэр намууд, нэр дэвшигчдийн амласан амлалтууд биелэгдэх эсэхэд та хэр итгэлтэй байна вэ? 2016 оны сонгуульд санал өгсөн байдлаар

	МАН	АН	МАХН	Бие даагч/Нам бус нэр дэвшигч
Бүрэн итгэлтэй	0.0%	3.8%	0.0%	0.0%
Ерөнхийдөө итгэлтэй	24.6%	12.3%	16.7%	10.5%
Ерөнхийдөө итгэлгүй	37.3%	44.6%	33.3%	40.8%
Огт итгэлгүй	32.5%	35.4%	45.8%	44.7%
Мэдэхгүй/Хариулаагүй	5.6%	3.8%	4.2%	3.9%


Өнөөгийн байдлаар Монголын нийгэмд тулгамдаад байгаа асуудлыг шийдэж чадах намыг оролцогчдын 19.8 хувь МАН, 15.9 хувь АН, 9.9 хувь МАХН гэж хариулжээ. **Сант Марал сангаас**¹ 2019 оны 04 сард явуулсан Улс төрийн барометр судалгааны үр дүнтэй харьцуулахад оролцогчдын 12.9% МАН, 7.3% АН, 3.8% МАХН, 2.5% Үнэн ба зөв намыг дээрх асуудлыг шийдвэрлэж чадна гэж үзсэн байна. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад намуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх байдал нэмэгдсэн байна. Тухайлбал МАН-ыг нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадна гэсэн хувь 6.9 пунктээр өссөн байна. Үүнээс үзвэл намуудын сүүлийн үед явуулж байгаа үйл ажиллагаа иргэдийн хүлээлтэд нийцэж байгааг харуулж байна.

Зураг 15. Монголын нийгмийн тулгамдсан асуудлууд болох ажилгүйдэл, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, авилга гэх мэт асуудлыг аль нам хамгийн сайн шийдэж чадах вэ? (Сант Марал Сангийн судалгааны үр дүнтэй харьцуулсан байдал)



Гэв иргэдийн 42 хувь нийгмийн тулгамдсан асуудлуудыг аль нам хүчин шийдвэрлэж чадах талаар мэдэхгүй гэсэн хариултыг өгч байна.

Зураг 16. Монголын нийгмийн тулгамдсан асуудлууд болох ажилгүйдэл, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, авилга гэх мэт асуудлыг аль нам хамгийн сайн шийдэж чадах вэ?



¹ Сант Марал сан. (2019). УЛС ТӨРИЙН БАРОМЕТР №18(52), 2019 ОН 3-4 САР. Улаанбаатар.

4.2. НАМУУДЫН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэдийн 23.9 хувь нь МАН, 16.1 хувь АН, 7.6 хувь МАХН-ыг зөв чиглэлд хөгжиж байна хэмээн үзсэн бол иргэдийн дийлэнх буюу 49.2 хувь намуудын зөв чиглэлд хөгжиж байгаа эсэхийг мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн. Харин иргэдийн 53.9 хувь нь АН, 34.7 хувь нь МАН, 8.4 хувь нь МНН, 4.2 хувь МАХН-ыг буруу чиглэлд хөгжиж байна гэж үзсэн бол 15.5 хувь нь намуудын буруу чиглэлд хөгжиж байгаа эсэхийг мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн. Иргэдийн үзэж байгаагаар зөв болон буруу чиглэлд хөгжиж байгаа намуудын жагсаалтыг МАН, АН, МАХН тэргүүлж байна. Гэвч намуудыг буруу чиглэлд хөгжиж байгаа хэмээн үзсэн иргэдийн хувь нь зөв чиглэлд хөгжиж байгаа хэмээн үзсэн иргэдээс хоёр дахин илүү байна. Тухайлбал АН-г зөв чиглэлд хөгжиж байгаа гэсэн иргэд 23.9 хувь байсан бол буруу чиглэлд хөгжиж байна хэмээн үзсэн иргэд 53.9 хувь буюу 30 пунктийн зөрүүтэй байна.

Зураг 17. Таны бодлоор улс төрийн намуудаас аль нам хөгжлийн хувьд зөв чиглэлрүү явж байна вэ?

	Зөв чиглэл
Монгол Ардын нам /МАН/	23.9%
Ардчилсан нам /АН/	16.1%
Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/	7.6%
Монголын Ногоон нам /МНН/	1.6%
Эх Орон нам	1.3%
Үнэн ба Зөв нам	1.3%
Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	1.1%
Ард Түмний Нам /АТН/	1.1%
Монголын Либерал нам /МЛН/	.3%
Бүгд найрамдах нам /БНН/	.8%
Монголын Социал Демократ Нам	.5%
Хөдөлмөрийн үндэсний нам /ХҮН/	.5%
Эх орончдын нэгдсэн нам /ЭОНН/	.5%
Ард түмнээ хайрлая нам /АТХН/	.5%
Зон олны нам /ЗОН/	.5%
Монгол шинэчлэлт нам /МШН/	.5%
Мэдэхгүй/Хариулаагүй	49.2%

Зураг 18. Таны бодлоор улс төрийн намуудаас аль нам хөгжлийн буруу чиглэлрүү явж байна вэ?

	Буруу чиглэл
Ардчилсан нам /АН/	53.9%
Монгол Ардын нам /МАН/	34.7%
Монголын Ногоон нам /МНН/	8.4%
Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/	4.2%
Иргэний зориг ногоон нам /ИЗНН/	1.8%
Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	.5%
Монгол Либерал Ардчилсан нам /МЛАН/	.3%
Эх Орон нам	.3%
Монголын Либерал нам /МЛН/	.3%
Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нам /МЭҮН/	.8%
Монголын Социал Демократ Нам	.3%
Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам	.3%
Иргэний Хөдөлгөөний Нам /ИХН/	.8%
Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам	.3%
Хамуг Монголын Хөдөлмөрийн нам /ХМХН/	.3%
Үнэн ба Зөв нам	.3%
Мэдэхгүй/Хариулаагүй	15.5%

Иргэдийн хувьд эдгээр намуудыг ямар үзэл баримтлал болон бодлогын чиглэл баримталж байгааг төдийлөн ялгаж ойлгохгүй байна. Учир бодлогын чиглэл бүр дээр иргэдийн 40 орчим хувь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн бол 25 орчим хувь МАН, 18 орчим хувь АН эдгээр асуудлуудыг хамгийн сайн хэрэгжүүлж чадна гэсэн хариултуудыг өгсөн.

Үүнээс үзвэл Барууны болон зүүний үзэл баримтлал гэсэн ойлголт нь Монголчуудын улс төрийн соёлын түвшинд төлөвшөөгүй, үнэт зүйл болоогүйтэй холбоотой байж болно. Энэ нь улс төрийн намууд барууны эсвэл зүүний үзэл баримтлалтай байх нь сонголт хийхэд нөлөөлөх хүчин зүйл болж чадаагүйг илтгэнэ.

Зураг 19. Таны бодлоор дараах бодлогуудыг аль нам хамгийн сайн хэрэгжүүлж чадах вэ?

№	Асуудал	МАН	АН	МАХН	МНН	ИЗНН	МУНН	МЛАН	МЛН	БНН	МСДН	АТН	МУАН	ХХН	Үнэн ба Зөв Нам	Мэдэхгүй
1	Ядуурал, ажлүгйдлийг бууруулах, шинээр ажлын байр нэмэх	25.5%	18.4%	7.4%	1.6%	0.8%	1.1%	0.5%	0.3%	1.1%	0.3%	0.3%	0.5%	0.3%	0.8%	40.3%
2	Эдийн засгийн тогтвортой байдал, төсвийн алдагдлыг тэнцвэржүүлэх, үрэлгэн зардлыг бууруулах, өрийн дарамтаас ангижрах	25.5%	18.4%	6.8%	1.8%	0.8%	0.8%	0.5%	0.3%	0.8%	0.3%	0.5%	0.5%	0.3%	0.5%	40.8%
3	Авлига, хээл хахуультай тэмцэх	25.5%	17.6%	7.4%	1.6%	0.8%	1.6%	0.5%	0.0%	0.8%	0.3%	0.3%	0.5%	0.3%	1.1%	40.5%
4	Боловсрол, сургалтын чанарыг дээшлүүлэх	23.9%	18.7%	6.1%	2.1%	1.1%	1.3%	0.5%	0.3%	1.1%	0.3%	0.5%	0.5%	0.3%	0.8%	41.3%
5	Нийгмийн халамж, хамгааллын бодлогыг зохистой хэрэгжүүлэх	25.8%	17.6%	6.3%	1.8%	1.1%	1.6%	0.5%	0.3%	0.5%	0.3%	0.3%	0.5%	0.3%	0.8%	41.1%
6	Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах	23.9%	18.7%	6.3%	1.6%	1.1%	1.3%	0.5%	0.0%	1.3%	0.3%	0.5%	0.5%	0.8%	0.8%	41.1%
7	Хувийн хэвшлийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, шинэ санаа шийдлийг дэмжих	25.5%	18.2%	6.6%	1.3%	1.1%	1.3%	0.5%	0.3%	0.8%	0.3%	0.3%	0.5%	0.3%	0.8%	41.3%
8	Улс орны тусгаар тогтнолыг баталгаажуулах-батлан хамгаалах бодлого	24.7%	17.9%	7.6%	1.3%	0.8%	1.1%	0.5%	0.0%	0.5%	0.5%	0.3%	0.5%	0.3%	1.1%	41.6%
9	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	25.3%	17.9%	6.8%	1.6%	0.8%	1.1%	0.5%	0.5%	0.5%	0.3%	0.3%	0.5%	0.3%	0.8%	41.8%



ДҮГНЭЛТ

- Энэхүү судалгааг Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт зохион байгуулсан ба нийт 380 иргэнийг ажил эрхлэлтийн байдал, орлогын түвшин, 2016 онд аль нам хүчний төлөө саналаа өгсөн зэргийг харгалзан судалгаанд түүвэрлэн хамруулсан. Судалгаанд хамрагдсан иргэд хувьд 22-оос 86 насны хоорондох төлөөлөл хамрагдсан ба хүйсийн хувьд эмэгтэй 57.1%, эрэгтэй 42.9% байлаа. Харин боловсролын хувьд дээд 50.3% дээд боловсролтой, 42.1% бүрэн дунд боловсролтой иргэд хамрагдсан бол ажил эрхлэлтийн хувьд бүх салбарт ажиллаж байгаа иргэдийн төлөөллийг хамруулсан болно.
- Иргэдийн хувьд төрийн эрх барьж байгаа **МАН, АН, МАХН-ын талаар мэдээлэл сайтай боловч бусад улс төрийн хүчин, нам эвслүүдийн талаар мэдээлэл хангалтгүй** байна.
- **Иргэд сонгуулиар дамжуулан сонгож байгаа улс төрийн үзэл баримтлалдаа эргэлзээтэй хандаж байна.** Тухайлбал 2016 оны сонгуулийн үр дүнд бий болсон намуудын УИХ дахь суудлын тоо нь Монгол улсын иргэдийн өнөөгийн улс төрийн үзэл баримтлал, чиг баримжааг төлөөлж чадах эсэхийг тодруулахад судалгаанд оролцогчдын **60 хувь нь** энэхүү сонгогдсон төлөөлөл нь иргэдийн улс төрийн үзэл баримтлал, үнэт зүйлсийг төлөөлж чадахгүй хэмээн үзэж байна.
- **Иргэд улс төрийн сонголт хийхдээ урт хугацааны бус, тухайн цаг үеийн нөхцөл байдал, үйл хөтлөлд хөтлөгдсөн шийдвэр гаргаж байна.** Тухайлбал сонгуулийн үеэр иргэдийн зөвхөн 26,9 хувь нь намын бодлого, үйл ажиллагааг дэмжиж саналаа өгсөн бол **62,1 хувь нь** сонгуулийн нөхцөл байдал, уур амьсгал зэрэгт үндэслэн сонгуулийн өдөр болон сонгуулийн сурталчилгааны өдрүүдэд шийдвэр гаргасан байна.
- **Иргэд тал хувь улс төрийн шийдвэр гаргахдаа намуудын бодлого, мөрийн хөтөлбөрт суурилсан үндэслэл бүхий оновчтой шийдвэр гаргаж чадахгүй байна.** Тухайлбал иргэдийн 58,4 хувь намын бодлого, үйл ажиллагааны чиглэл болон мөрийн хөтөлбөрт үндэслэн тухайн намыг сонгож байгаа бол **41.6 хувь** тухайн намаас нэр дэвшигч хувь хүний шинж чанар, өөр сайн нэр

дэвшигч байхгүй, урамшуулал зэрэг хүчин зүйлд үндэслэн сонголтоо хийж байна.

- **Иргэд улс төрийн шийдвэр гаргахдаа хүлээн зөвшөөрөгдөхүйц бие даасан шийдвэр гаргаж чадахгүй байна.** Тухайлбал иргэд улс төрийн сонголт хийхдээ намын бодлого, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон өөрийн үзэл бодолд тулгуурлан сонголт хийсэн байдал 41 хувь байгаа бол үлдсэн **59 хувь нь** хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад субъектийн нөлөөлөлд автагдаж сонголт хийж байна
- **Иргэдийн намуудад итгэх итгэл болон дэмжлэг маш сул байна.** Тухайлбал 2020 оны сонгуульд одоогийн нам хүчнийг дэмжиж саналаа өгөх иргэдийн саналын хувийг авч үзвэл 19.2 хувь нь МАН, 18.4 хувь нь АН, 10 хувь нь МАХН, 11.7 хувь нь бусад нам төлөө саналаа өгнө гэсэн бол **45,9 хувь** аль намд саналаа өгөхөө мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн. Харин 2020 оны сонгуульд нам хүчнийг дэмжихгүй вэ гэдгийг тодруулахад **48 хувь нь АН, 44 хувь нь МАН, 4,5 хувь нь МАХН, 15,8 хувь** бусад нам хүчний төлөө саналаа өгөхгүй гэсэн бол 9,5 хувь нь ямар нэг шийдвэр гаргаагүй буюу мэдэхгүй байна. Тухайн намуудыг дэмжигүй гэдэг хариултын хувь дэмжинэ гэж хариулсан хувиасаа 20-оос 25 пунктээр их байна. Үүнээс үзвэл намуудын сөрөг дэмжлэг өндөр, эерэг дэмжлэг бага байна.
- **Олон ургальч үзэл бодлыг илэрхийлсэн олон намын тогтолцоонд иргэдийн итгэх итгэл суларсан байна.** Тухайлбал судалгаанд оролцогчдын дийлэнх буюу **59,5 хувь** ер нь намын хэрэг байхгүй хүчтэй ерөнхийлөгчийн засаглал байх ёстой гэсэн үзэл давамгайлж байгаа бол үүний зэрэгцээ гурав дахь хүчин гэж хэрэггүй хоёр намтай байхад хангалттай гэсэн үзэл **13,9 хувийг** бүрдүүлж байгаа нь намд итгэх улам суларсан байгааг харж болно. Харин олон ургальч үзэл бодол бүхий олон намын тогтолцоотой байх ёстой гэж иргэдийн **14,7 хувь нь** үзэж байна.
- **Иргэдийн намуудаас хүлээх хүлээлт МАШ БАГА байна.** Тухайлбал иргэдийн **82 хувь нь** намууд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө биелүүлж чадахгүй гэж үзэж байгаа бол Монголын нийгмийн тулгамдсан асуудлууд болох ажилгүйдэл, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, авилга гэх мэт асуудлыг аль нам хамгийн сайн шийдэх вэ гэсэн асуултад **42 хувь** аль нам хүчин шийдэж чадахыг мэдэхгүй буюу намууд шийдэж чадахгүй гэсэн хариултыг өгсөн.
- **Иргэдийн дийлэнх намуудыг бодлого хөтөлбөр, үзэл баримтлалын хувьд буруу чиглэлд хөгжиж байна хэмээн үзэж байна.** Тухайлбал иргэд намуудыг зөв чиглэл рүү бус буруу чиглэл бүү хөгжиж байна хэмээн үзэж байна.
- Иргэдийн хувьд улс төрийн нам, эвслүүдийн бодлого, үзэл баримтлал, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн талаарх мэдлэг, ойлголт маш сул байна.



ХАВСРАЛТ

1. Таны нас

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
21-24	65	17.1	17.1	17.1
25-29	67	17.6	17.6	34.7
30-34	52	13.7	13.7	48.4
35-39	35	9.2	9.2	57.6
40-44	30	7.9	7.9	65.5
45-49	30	7.9	7.9	73.4
50-54	34	8.9	8.9	82.4
55-59	23	6.1	6.1	88.4
60-64	16	4.2	4.2	92.6
65-69	12	3.2	3.2	95.8
70-аас дээш	16	4.2	4.2	100.0
Нийт	380	100.0	100.0	

2. Таны хүйс

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Эрэгтэй	163	42.9	42.9	42.9
Эмэгтэй	217	57.1	57.1	100.0
Нийт	380	100.0	100.0	

3. Таны боловсрол

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Дээд	191	50.3	50.3	50.3
Бүрэн дунд	160	42.1	42.1	92.4
Бүрэн бус дунд	25	6.6	6.6	98.9
Бага	4	1.1	1.1	100.0
Нийт	380	100.0	100.0	

4. Өрхийн сарын дундаж орлого

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
300,000 хүртэл	45	11.8	11.8	11.8
300,001-700,000	129	33.9	33.9	45.8
700,001-1,100,000	95	25.0	25.0	70.8
1,100,001-1,600,000	65	17.1	17.1	87.9
1,600,000-аас дээш	46	12.1	12.1	100.0
Нийт	380	100.0	100.0	

5. Таны ажил эрхлэлтийн байдал

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Төрийн байгууллага	57	15.0	15.0	15.0
Хувийн байгууллага	133	35.0	35.0	50.0
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	87	22.9	22.9	72.9
Суралцдаг (оюутан, сурагч)	29	7.6	7.6	80.5
Тэтгэвэрт, группэд	56	14.7	14.7	95.3
Эрхэлсэн ажилгүй	17	4.5	4.5	99.7
ОУ-ын байгууллага	1	.3	.3	100.0
Нийт	380	100.0	100.0	

6. Та улс төрийн намын гишүүн үү?

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Тийм	48	12.6	12.6	12.6
Үгүй	332	87.4	87.4	100.0
Нийт	380	100.0	100.0	

Тийм бол Намын нэрийг хэлнэ үү.

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
МАН	21	5.5	43.8	43.8
АН	20	5.3	41.7	85.4
МАХН	4	1.1	8.3	100.0
Монголын Ногоон нам	1	.3	2.1	87.5
Монгол Үндэсний Ардчилсан Нам	1	.3	2.1	89.6
Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч	1	.3	2.1	91.7
Нийт	48	12.6	100.0	
System	332	87.4		
	380	100.0		

7. 2016 оны сонгуульд аль намаас нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн вэ?

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
МАН	126	33.2	33.2	33.2
АН	130	34.2	34.2	67.4
МАХН	48	12.6	12.6	80.0
Бие даагч/Нам бус нэр дэвшигч	76	20.0	20.0	100.0
Нийт	380	100.0	100.0	

8. 2016 оны сонгуулийн үр дүнд бий болсон нам эвслүүдийн УИХ дахь суудлын тоо манай улсад байгаа өнөөгийн улс төрийн үзэл бодлыг бүрэн төлөөлж байна гэж та боддог уу?

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Тийм	71	18.7	18.7	18.7
Үгүй	228	60.0	60.0	78.7
Мэдэхгүй/Хариулаагүй	81	21.3	21.3	100.0
Нийт	380	100.0	100.0	

9. Та 2016 оны сонгуулиар аль нам, улс төрийн хүчинд санал өгөхөө хэзээ эцэслэн шийдсэн бэ?

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Сонгуулийн өдөр	100	26.3	26.3	26.3
Сонгуулийн сурталчилгааны өдрүүд (Сонгууль болохоос 45 хоногийн өмнө)	136	35.8	35.8	62.1
Тухайн намын үйл ажиллагааны чиглэл, бодлогыг дэмждэг учраас өмнө шийдсэн	82	21.6	21.6	83.7
Намын гишүүн учраас намаа сонгосон	20	5.3	5.3	88.9
Мэдэхгүй/Хариулаагүй	42	11.1	11.1	100.0
Нийт	380	100.0	100.0	

10. Та 2016 оны УИХ-ын сонгуульд дээрх намыг сонгож саналаа өгөхдөө ямар хүчин зүйлийг харгалзан сонголт хийсэн бэ?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
Тухайн намаас нэр дэвшигч хувь хүний шинж чанар	119	24.8%	31.3%
Намын баримталдаг бодлого, үйл ажиллагааны чиглэл	128	26.7%	33.7%
Намын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр	152	31.7%	40.0%
Урамшуулал өгсөн болохоор /гарын бэлэг, хүнсний зүйл гэх мэт/	6	1.3%	1.6%
Өөр сайн нэр дэвшигч байгаагүй тул	75	15.6%	19.7%
Нийт	480	100.0%	126.3%

11. Санал өгөх шийдвэр гаргахад хэн эсвэл юу танд хамгийн ихээр нөлөөлсөн бэ?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
Намын бодлого эсвэл нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр	162	33.1%	42.6%
Хэвлэл мэдээлэл	97	19.8%	25.5%
Гэр бүлийн гишүүд/хамаатан садан/найз нөхөд	58	11.8%	15.3%
Намын удирдлага	10	2.0%	2.6%
Иргэний нийгмийн байгууллагууд	9	1.8%	2.4%
Орон нутгийн лидерүүд	6	1.2%	1.6%
Баг хорооны дарга, хэсгийн ахлагчийн зөвлөгөөг	14	2.9%	3.7%
Интернет /Сошиал медиа/	18	3.7%	4.7%
Facebook, Twitter, Instagram гэх мэт нийгмийн сүлжээ	26	5.3%	6.8%
Шашны бүлэг/шашны манлайлагч	3	.6%	.8%
Өөрийнхөө бодлоор	39	8.0%	10.3%
Мэдэхгүй/Хариулаагүй	48	9.8%	12.6%
Нийт	490	100.0%	128.9%

12. Та 2020 оны УИХ-ын сонгуульд дараах намуудаас Аль намыг дэмжиж оролцох вэ?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
Монгол Ардын нам /МАН/	70	16.8%	18.4%
Ардчилсан нам /АН/	73	17.5%	19.2%
Монголын Ногоон нам /МНН/	4	1.0%	1.1%
Иргэний зориг ногоон нам /ИЗНН/	7	1.7%	1.8%
Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	4	1.0%	1.1%
Эх Орон нам	3	.7%	.8%
Бүгд найрамдах нам /БНН/	2	.5%	.5%
Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нам /МЭҮН/	2	.5%	.5%
Ард Түмний Нам /АТН/	5	1.2%	1.3%
Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам	3	.7%	.8%
Иргэний Хөдөлгөөний Нам /ИХН/	2	.5%	.5%
Хөгжлийн Хөтөлбөрийн Нам	2	.5%	.5%
Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/	38	9.1%	10.0%
Хөдөлмөрийн үндэсний нам /ХҮН/	2	.5%	.5%
Ард түмнээ хайрлая нам /АТХН/	2	.5%	.5%
Үнэн ба Зөв нам	7	1.7%	1.8%
Мэдэхгүй/Хариулаагүй	190	45.7%	50.0%
Нийт	416	100.0%	109.5%

13. Та 2020 оны УИХ-ын сонгуульд дараах намуудаас Аль намыг дэмжихгүй вэ?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
Монгол Ардын нам /МАН/	174	37.0%	45.9%
Ардчилсан нам /АН/	183	38.9%	48.3%
Монголын Ногоон нам /МНН/	33	7.0%	8.7%
Иргэний зориг ногоон нам /ИЗНН/	11	2.3%	2.9%
Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	2	.4%	.5%
Эх Орон нам	5	1.1%	1.3%
Монголын Либерал нам /МЛН/	1	.2%	.3%
Бүгд найрамдах нам /БНН/	2	.4%	.5%
Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нам /МЭҮН/	2	.4%	.5%
Монгол Үндэсний Ардчилсан Нам /МҮАН/	1	.2%	.3%
Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам	1	.2%	.3%
Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/	17	3.6%	4.5%
Миний Монгол нам /ММН/	2	.4%	.5%
Мэдэхгүй/Хариулаагүй	36	7.7%	9.5%
	470	100.0%	124.0%

14. Сонгуулийн сурталчилгааны үеэр намууд, нэр дэвшигчдийн ярьж байсан амлалтууд биелэгдэх эсэхэд та хэр итгэлтэй байна вэ?

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Бүрэн итгэлтэй	5	1.3	1.3	1.3
Ерөнхийдөө итгэлтэй	63	16.6	16.6	17.9
Ерөнхийдөө итгэлгүй	152	40.0	40.0	57.9
Огт итгэлгүй	143	37.6	37.6	95.5
Мэдэхгүй/Хариулаагүй	17	4.5	4.5	100.0
Нийт	380	100.0	100.0	

15. Монголын нийгмийн тулгамдсан асуудлуудыг аль нам хамгийн сайн шидэж чадах бол?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
Монгол Ардын нам /МАН/	82	19.8%	21.6%
Ардчилсан нам /АН/	66	15.9%	17.4%
Монголын Ногоон нам /МНН/	6	1.4%	1.6%
Иргэний зориг ногоон нам /ИЗНН/	10	2.4%	2.6%
Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	2	.5%	.5%
Эх Орон нам	7	1.7%	1.8%
Монголын Либерал нам /МЛН/	2	.5%	.5%
Бүгд найрамдах нам /БНН/	4	1.0%	1.1%
Ард Түмний Нам /АТН/	8	1.9%	2.1%
Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам	1	.2%	.3%
Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/	41	9.9%	10.8%
Хөдөлмөрийн үндэсний нам /ХҮН/	4	1.0%	1.1%
Эх орончдын нэгдсэн нам /ЭОНН/	2	.5%	.5%
Үнэн ба Зөв нам	5	1.2%	1.3%
Мэдэхгүй/Хариулаагүй	174	42.0%	45.8%
Нийт	414	100.0%	108.9%

16. Намуудын талаар Та ямар бодолтой байна вэ?

	Тоо	Хувь	Бодит хувь	Хуримтлагдсан хувь
Олон ургалч үзэл бодлыг илэрхийлсэн олон намтай байх ёстой	56	14.7	14.7	14.7
Ер нь гурав дахь хүчин гэж хэрэггүй-хоёр намтай байхад хангалттай	53	13.9	13.9	28.7
Ер нь намуудын хэрэг байхгүй-хүчтэй ерөнхийлөгчтэй байх нь зөв	226	59.5	59.5	88.2
Мэдэхгүй/Хариулаагүй	45	11.8	11.8	100.0
Нийт	380	100.0	100.0	

17. Таны бодлоор улс төрийн намуудаас аль нам ерөнхийдөө хөгжлийн хувьд зөв чиглэл рүү явж байна вэ?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
Монгол Ардын нам /МАН/	91	22.3%	23.9%
Ардчилсан нам /АН/	61	15.0%	16.1%
Монголын Ногоон нам /МНН/	6	1.5%	1.6%
Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	4	1.0%	1.1%
Эх Орон нам	5	1.2%	1.3%
Монголын Либерал нам /МЛН/	1	.2%	.3%
Бүгд найрамдах нам /БНН/	3	.7%	.8%
Монголын Социал Демократ Нам	2	.5%	.5%
Ард Түмний Нам /АТН/	4	1.0%	1.1%
Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/	29	7.1%	7.6%
Хөдөлмөрийн үндэсний нам /ХҮН/	2	.5%	.5%
Эх орончдын нэгдсэн нам /ЭОНН/	2	.5%	.5%
Ард түмнээ хайрлая нам /АТХН/	2	.5%	.5%
Үнэн ба Зөв нам	5	1.2%	1.3%
Зон олны нам /ЗОН/	2	.5%	.5%
Монгол шинэчлэлт нам /МШН/	2	.5%	.5%
Мэдэхгүй/Хариулаагүй	187	45.8%	49.2%
Нийт	408	100.0%	107.4%

18. Таны бодлоор улс төрийн намуудаас аль нам ерөнхийдөө хөгжлийн хувьд буруу чиглэл рүү явж байна вэ?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
Монгол Ардын нам /МАН/	132	28.3%	34.7%
Ардчилсан нам /АН/	205	43.9%	53.9%
Монголын Ногоон нам /МНН/	32	6.9%	8.4%
Иргэний зориг ногоон нам /ИЗНН/	7	1.5%	1.8%
Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	2	.4%	.5%
Монгол Либерал Ардчилсан нам /МЛАН/	1	.2%	.3%
Эх Орон нам	1	.2%	.3%
Монголын Либерал нам /МЛН/	1	.2%	.3%
Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нам /МЭҮН/	3	.6%	.8%
Монголын Социал Демократ Нам	1	.2%	.3%
Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам	1	.2%	.3%
Иргэний Хөдөлгөөний Нам /ИХН/	3	.6%	.8%
Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам	1	.2%	.3%
Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/	16	3.4%	4.2%
Хамуг Монголын Хөдөлмөрийн нам /ХМХН/	1	.2%	.3%
Үнэн ба Зөв нам	1	.2%	.3%
Мэдэхгүй/Хариулаагүй	59	12.6%	15.5%
Нийт	467	100.0%	122.9%

19. Таны хамгийн их дэмждэг улс орныг сайн удирдаж чадах улс төрч хэн бэ?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
У. Хүрэлсүх	93	21.2%	34.6%
Х. Баттулга	56	12.8%	20.8%
Л. Оюун-Эрдэнэ	48	11.0%	17.8%
Н. Энхбаяр	33	7.5%	12.3%
Ж. Батзандан	28	6.4%	10.4%
Б. Жаргалсайхан	22	5.0%	8.2%
Г. Занданшатар	19	4.3%	7.1%
С. Жавхлан	19	4.3%	7.1%
Ц. Нямдорж	15	3.4%	5.6%
С.Ганбаатар	14	3.2%	5.2%
Л. Болд	9	2.1%	3.3%
Б. Бат-Эрдэнэ	6	1.4%	2.2%
Н. Учрал	5	1.1%	1.9%
Ц. Даваасүрэн	5	1.1%	1.9%
Л. Гүндалай	2	.5%	.7%
Ё. Баатарбилэг	1	.2%	.4%
С. Чинзориг	2	.5%	.7%
З. Нарантуяа	1	.2%	.4%
Ц. Мөнхориг	2	.5%	.7%
Б. Наранхүү	1	.2%	.4%
Н.Номтойбаяр	3	.7%	1.1%
Д. Тэрбишдавга	2	.5%	.7%
М. Энхболд	3	.7%	1.1%
Р. Амаржаргал	5	1.1%	1.9%
Д. Эрдэнэбат	2	.5%	.7%
С.Баяр	1	.2%	.4%
Ш. Раднаасэд	1	.2%	.4%
Н. Алтанхуяг	2	.5%	.7%
Х. Нямбаатар	4	.9%	1.5%
Д. Лүндээжанцан	1	.2%	.4%
М. Батчимэг	1	.2%	.4%
Э. Батүүл	2	.5%	.7%
Л. Энх-Амгалан	3	.7%	1.1%
Ч. Хүрэлбаатар	3	.7%	1.1%
Д. Оюунхорол	3	.7%	1.1%
Б. Дэлгэрсайхан	1	.2%	.4%
Т. Аюурсайхан	6	1.4%	2.2%
С. Эрдэнэ	5	1.1%	1.9%
Д. Хаянхярваа	3	.7%	1.1%
С. Оюунгэрэл	1	.2%	.4%
Ч. Улаан	1	.2%	.4%
М. Энхсайхан	1	.2%	.4%
Д. Сарангэрэл	1	.2%	.4%
О. Баасанхүү	2	.5%	.7%
Нийт	438	100.0%	162.8%

20. Таны бодлоор улс орныг сайн удирдаж чадах хүн ямар байх хэрэгтэй гэж үзэж байна вэ?

	Давтамж		Нийт кейсээс бодсон хувь
	Тоо	Хувь	
Улс орныхоо төлөө сэтгэлтэй	43	10.6%	13.1%
Шударга	171	42.0%	52.0%
Тууштай	3	.7%	.9%
Удирдах чадвартай	2	.5%	.6%
Ард иргэдээ сонсдог, нээлттэй	49	12.0%	14.9%
Мэдлэг боловсролтой	36	8.8%	10.9%
Манлайлагч	10	2.5%	3.0%
Бусдын төлөө гэсэн сэтгэлтэй	1	.2%	.3%
Өөрийн гэсэн үзэл бодолтой	11	2.7%	3.3%
Ухамсартай	1	.2%	.3%
Зөв бодолтой	5	1.2%	1.5%
Амласандаа хүрдэг	23	5.7%	7.0%
Даруу төлөв	2	.5%	.6%
Хариуцлагатай	11	2.7%	3.3%
Үндэсний үзэлтэй	7	1.7%	2.1%
Шуналгүй	6	1.5%	1.8%
Зорилготой	3	.7%	.9%
Хүн чанартай	8	2.0%	2.4%
Ажил хэрэгч	1	.2%	.3%
Хөдөлмөрч	3	.7%	.9%
Зарчимч	4	1.0%	1.2%
Итгэл даасан	2	.5%	.6%
Туршлагатай	2	.5%	.6%
Асуудлыг шийдэж чаддаг	1	.2%	.3%
Ёс суртахуунтай	2	.5%	.6%
Нийт	407	100.0%	123.7%

21. Таны бодлоор дараах бодлогуудыг аль нам хамгийн сайн хэрэгжүүлж чадах вэ?

	МАН	АН	МНН	ИЗНН	МҮНН	БНН	АТН	МАХН	Үнэн ба Зөв Нам	Мэдэггүй/Хариулаагүй
Ядуурал, ажилгүйдлийг бууруулах, шинээр ажлын байр нэмэх	25.5%	18.4%	1.6%	.8%	1.1%	1.1%	.3%	7.4%	.8%	40.3%
Эдийн засгийн тогтвортой байдал, төсвийн алдагдлыг тэнцвэржүүлэх, үрэлгэн зардлыг бууруулах, өрийн дарамтаас ангижрах	25.5%	18.4%	1.8%	.8%	.8%	.8%	.5%	6.8%	.5%	40.8%
Авлига, хээл хахуультай тэмцэх	25.5%	17.6%	1.6%	.8%	1.6%	.8%	.3%	7.4%	1.1%	40.5%
Боловсрол, сургалтын чанарыг дээшлүүлэх	23.9%	18.7%	2.1%	1.1%	1.3%	1.1%	.5%	6.1%	.8%	41.3%
Нийгмийн халамж, хамгааллын бодлогыг зохистой хэрэгжүүлэх	25.8%	17.6%	1.8%	1.1%	1.6%	.5%	.3%	6.3%	.8%	41.1%
Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах	23.9%	18.7%	1.6%	1.1%	1.3%	1.3%	.5%	6.3%	.8%	41.1%
Хувийн хэвшлийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, шинэ санаа шийдлийг дэмжих	25.5%	18.2%	1.3%	1.1%	1.3%	.8%	.3%	6.6%	.8%	41.3%
Улс орны тусгаар тогтнолыг баталгаажуулах-батлан хамгаалах бодлого	24.7%	17.9%	1.3%	.8%	1.1%	.5%	.3%	7.6%	1.1%	41.6%
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	25.3%	17.9%	1.6%	.8%	1.1%	.5%	.3%	6.8%	.8%	41.8%



Монгол дахь Конрад-Аденауэр-Сан
Сөүлийн гудамж Браухаус 22
Улаанбаатар хот 14253
Монгол улс

Утас: +976-11-319135/319136
Факс: +976-11-319137
www.kas.de/mongolei
www.facebook.com/kas.mongolei
info.mongolia@kas.de